



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2014 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 264

Мандалговь

Хөрөнгө бэлтгэж бүртгэх тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, “Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалтыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. “Дундговь-Ус” ОНӨҮГазарт хавсралтын дагуу өөрийн хөрөнгө болон орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр бэлтгэсэн 137’804’800 /нэг зуун гучин долоон сая найман зуун дөрвөн мянга найман зуу/ төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэж авахыг зөвшөөрсүгэй.

2. Шинээр бэлтгэсэн эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын данс бүртгэлд бүртгэж авахыг “Дундговь-Ус” ОНӨҮГазрын дарга Р.Энхмаад даалгасугай.


3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

ДАРГА

С.БУДЖАВ



Аймгийн ИТХТ-ийн 2014 оны ... сарын ... өдрийн ... р тогтоолын хавсралт



Бүртгэлд авах хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	45Ж нам даралтын тогоо	Ком	1	9'960'000	9'960'000
2	Конторын барилгын засвар	Өрөө	4	-	15'845'800
3	Нийтийн халуун усны өргөтгөл	ком	1	111'999'000	111'999'000
Дүн					137'804'800